

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр

№ 22/05

Улаанбаатар хот

“ЛэндБонд”-ын хүүгийн нөхцөлд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 226 тоот “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэх журам”-ын 3.21, 4.4 дүгээр зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2021 оны 02 дугаар сарын 5-ны өдрийн 21/08 тогтоолоор батлагдсан “Компанийн 2021 оны эх үүсвэрийн төлөвлөгөө”, Компанийн ТУЗ-ийн 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 21/38 тоот тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгох үнэт цаасны ерөнхий нөхцөл”, Компанийн ТУЗ-ийн 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит бус хурлын санал хураалтын тооллогын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн ТУЗ-ийн 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 21/38 тоот тогтоолын дагуу Компанийн өрийн бичиг (цаашид “ЛэндБонд”)-ийг олон нийтэд хэсэгчлэн санал болгохоор шийдвэрлэсэн бөгөөд ЛэндБондын хоёрдугаар ээлжийн хүрээнд нийт 3,100,000,000.00 (Гурван тэрбум нэг зуун сая) төгрөгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэн олон нийтэд санал болгож, хөрөнгө татан төвлөрүүлэх боломжтой байгааг дурдсугай.
2. Монгол Улсын зах зээлийн нөхцөл байдал, инфляцын түвшинтэй холбогдуулан ЛэндБондын хоёрдугаар ээлжид тооцох хүүгийн хэмжээг шинэчлэн тогтоож, жилийн (365 хоногт) 15.0% байхаар тогтоосугай.
3. ЛэндБондын хоёрдугаар ээлжийг Компанийн ТУЗ-ийн 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 21/38 тоот тогтоолд заасан ерөнхий нөхцөлийг баримтлан олон нийтэд санал болгох, ингэхдээ хүүгийн хэмжээг энэхүү тогтоолын 2 дахь хэсэгт заасан өөрчлөгдсөн дүнгээр буюу жилийн 15.0%-аар тооцохыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д даалгасугай.
4. ЛэндБондын хоёрдугаар ээлжийг олон нийтэд санал болгохтой холбогдуулан шаардлагатай зөвшөөрөл, баримт бичгийг бүрдүүлэх, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

О.БОЛДБААТАР